



СУДАЛГААНЫ АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ УРИЛГА

Судалгааны ажлын сэдэв: Монгол Улсын банкнаас бусад үндэсний томоохон аж ахуйн нэгжүүдийн хувьцааг хөрөнгийн биржээр арилжаалах боломжийн судалгаа

Үндэслэл: Төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 онд баримтлах үндсэн чиглэлийн хүрээнд Санхүүгийн зах зээлийн бүтцийг олон тулгууртай болгох, санхүүгийн зуучлалыг хүртээмжтэй болгох ажлыг эрчимжүүлэх, үүний тулд холбогдох бодлогын судалгаа шинжилгээний ажлыг гүйцэтгэх шаардлага тулгарч байна.

Дээрх шаардлагын дагуу тус судалгааны ажлыг хийж гүйцэтгэх хөндлөнгийн судалгааны баг, байгууллагыг сонгон шалгаруулна.

Судалгааны үндсэн зорилго: Монгол Улсын банкнаас бусад үндэсний томоохон аж ахуйн нэгжүүдийн хувьцааг хөрөнгийн биржээр дамжуулан арилжаалах боломжийг бүх талаас нь судалж, цаашид авах бодлого, зохицуулалтын арга хэмжээний саналыг боловсруулахад оршино.

Судалгааны ажлын удирдамж болон бусад шаардлагатай мэдээллийг Монголбанкны https://www.mongolbank.mn/documents/zar/2017/20170407_tor2.pdf хаягаар орж үзнэ үү.

Судалгаа хийх саналаа өгөх эцсийн хугацаа	<ul style="list-style-type: none">• 2017 оны 04 дүгээр сарын 17
Судалгааг гүйцэтгэх хугацаа	<ul style="list-style-type: none">• 2017 оны 04 дүгээр сарын 24-ний өдрөөс 07 дугаар сарын 20-ны өдөр
Судалгааны ажлыг гүйцэтгэх үнийн дүн	<ul style="list-style-type: none">• 25 сая төгрөг
Судалгаа хийх санал өгөхөд бүрдүүлэх материал	<p>Мэдүүлгээ ирүүлж буй судалгааны баг, байгууллага нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох дараах материалыг ирүүлнэ:</p> <ul style="list-style-type: none">• Судалгааны баг, байгууллагын товч танилцуулга• Судалгаа, шинжилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулсан туршлага, түүний талаарх мэдээлэл;• Судалгаа, шинжилгээ хийх, тайлан дүгнэлт боловсруулах чиглэлээр мэргэжлийн боловсон хүчний танилцуулга;• Судалгааг хэрхэн хийж гүйцэтгэх талаарх танилцуулга;• Судалгааны ажлыг хийж гүйцэтгэх нарийвчилсан төлөвлөгөө

Бүрдүүлэх материалыг gangerel@mongolbank.mn цахим хаягаар **2017 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн дотор** ирүүлнэ үү.